

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Аудитын тайлан**

**Аудитын код: САГ-2018/148/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я.Самбууням  
Утас: 261885 Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Аудитор Б.Долгоржав  
Утас: 260512 Цахим хаяг: [dolgorjavb@audit.gov.mn](mailto:dolgorjavb@audit.gov.mn)


Гэрээт аудитор Э.Гансүх  
Гэрээт аудитор Ж.Нямцэцэг



Улаанбаатар хот

## Агуулга

|       |                                                                                  |    |
|-------|----------------------------------------------------------------------------------|----|
| 1     | Аудитын гэрчилгээ .....                                                          | 0  |
| 2     | Аудитын тайлан.....                                                              | 1  |
| 2.1   | Оршил.....                                                                       | 1  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....            | 1  |
| 2.3   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....                  | 2  |
| 2.4   | Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 3  |
| 2.5   | Дотоод хяналт .....                                                              | 3  |
| 2.6   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                            | 4  |
| 2.7   | Шилэн дансны мэдээлэл .....                                                      | 4  |
| 2.8   | Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....                      | 4  |
| 2.9   | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....          | 4  |
| 2.9.1 | Авлагын таллаар.....                                                             | 4  |
| 2.9.2 | Бараа материалын талаар .....                                                    | 4  |
| 2.9.3 | Үндсэн хөрөнгийн талаар.....                                                     | 5  |
| 2.9.4 | Зардлын талаар .....                                                             | 6  |
| 2.10  | Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....                                       | 7  |
| 2.11  | Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....                                      | 7  |
| 2.12  | Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....                                          | 7  |
| 2.13  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....                                                  | 7  |
| 2.14  | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....                       | 7  |
| 2.15  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....                                           | 7  |
| 3     | Менежментийн захидал .....                                                       | 8  |
| 3.1   | Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар .....                                       | 9  |
| 3.2   | Зардлын талаар .....                                                             | 10 |
| 3.3   | Эхний үлдэгдлийн талаар.....                                                     | 11 |
| 4     | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                        | 13 |
| 4.1   | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....                                   | 13 |
| 4.2   | Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....                                 | 14 |
| 4.3   | Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....                     | 16 |
| 4.4   | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                    | 17 |
| 4.5   | Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                                  | 19 |



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Э.СОДНОМЖАМЦ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт


Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үндэслэл, санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт,

түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд бараа материалын дансан дахь хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэх, шатахуун зарцуулалтад хяналт тавьж ажиллах, өөрийн үйл ажиллагаанд хамрагдах үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгах, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 2 дугаар сарын 9-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн

баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав, гэрээт аудитор Э.Гансүх, Ж.Нямцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 97 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эрүүл мэндийн хөгжлийн төв санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндийн хөгжлийн төв” байгуулах тухай 2012 оны 50 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/203 дугаар тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг 75 орон тоотойгоор баталсан байна.

#### **Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:**

Эрхэм зорилго: "Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нотолгоо бүрдүүлэх, байгууллага, хүний нөөц, техник технологи, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, салбарын удирдлага, манлайллыг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх"

#### **Үйл ажиллагааны стратегийн зорилт:**

- эрүүл мэндийн салбарын бодлогын болон тогтолцооны судалгааг хөгжүүлэх;
- статистик мэдээ, мэдээлэл, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах;
- эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрхзүй, шалгалт баталгаажуулалт, засвар үйлчилгээ, сургалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;
- эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжин, чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх;
- эмийн зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын эмийн зах зээлийн хөгжлийн түвшинд нийцүүлэх;
- байгууллагын бие даасан, тогтвортой байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах.

Эрүүл мэндийн хөгжлийн төв зорилго зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын бодлого судалгааг боловсруулах, статистик мэдээ, мэдээлэл гаргах, эмнэлгийн тоног

төхөөрөмжийн баталгаажуулалт хийх, эмийн зохицуулалтын үйл ажиллагааг хянах, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн сургалт хөгжлийг дэмжих, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулан иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлж ажилладаг байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

## **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 22 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.


Эрүүл мэндийн хөгжлийн төв нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

## **2.5 Дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай гэж үзлээ.

Дотоод аудитын албыг 2017 онд байгуулсан бөгөөд мэргэжлийн сургалт, эрх олгох шалгалт тус бүрт хяналт тавьж, иргэдээс ирүүлсэн санал гомдлыг тухай бүр шийдвэрлүүлж барагдуулан ажилласан байна.



## 2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүл мэндийн хөгжлийн төв хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн 9 зорилтот түвшинг баталгаажуулан хэрэгжүүлж ажилласан байна.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 4,095,553.9 мянган төгрөгийн төсөв батлагдснаас гүйцэтгэлээр 3,945,801.8 мянган төгрөгийг, нэмэлт санхүүжилтийн 248,984.1 мянган төгрөгийн орлогын 243,834.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 15,212.8 мянган төгрөгөөр биелүүлсэн байна. Урсгал зардлыг батлагдсан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад нийт зардлын дүнгээр хэтрээгүй боловч цалин хөлс, хангамж бараа материалын зардлын бүлгийн дүнгээр 3.9-7.1 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. 2017 онд нийт 16 төрлийн мэдээллийг мэдээний онцлогоос шалтгаалан бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр, тухай бүр гэсэн давтамжтайгаар нийт 507 ажил гүйлгээг байршуулсан. Тухай бүр байршуулдаг цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зардлын мөнгөн гүйлгээ нийт 6,445,438.8 мянган төгрөгийн үнэ бүхий 156 ажил гүйлгээ, мөнгөн хөрөнгөтэй холбоотой тушаал, шийдвэрийн 272 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ 75,126.4 мянган төгрөгийн 8 ажил гүйлгээний мэдээллүүдийг тухай бүрт шилэн дансаны вэб сайтад тавьж ажилласан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.


Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Авлагын талаар

Тус байгууллага тайлант хугацаанд тоног төхөөрөмжийн, барааг хэрэглэлтийн үйлчилгээний орлого 6,517.8 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй, тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" гэсэн заалт, аудитын "Хэмжилт" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу авлага дансанд бүртгэж залруулах.

## 2.9.2 Бараа материалын талаар

Бараа материалын бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Шатахуун зарцуулалтыг тулгаж шалгахад 12,636.6 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоо бодож, хянаж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, аудитын "Толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

Үнэт цаасны зарцуулалтыг тухай бүр нь бүртгээгүйгээс тайлан болон тооллогын бүртгэл 385 ширхэг буюу 5,696.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу авлага дансанд бүртгэж залруулах.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 23,580.0 мянган төгрөгийн хөрөнгө тодорхой тушаал шийдвэргүй Эрүүл мэндийн яаманд ашиглагдаж, биетээр оршин байхгүй байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, даснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, энэ журмын 4.2-т заасны дагуу зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан ... хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж бүртгэнэ" гэсэн заалт, ЭМЯ-ны 2015 оны НБББББ-ийн 4.4.4-т "Үндсэн хөрөнгө гэдэг нь үйлчилгээ, удирдлагын хэрэгсэлд ашиглаж байгаа эсвэл бусад түрээслүүлэхээр байгууллагын эзэмшилд буй тухайн байгууллагын эзэмшилд байгаа нэг жилээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдах эдхн эртгөө элэгдлийн байдлаар зардалд аажмаар шингээж байдаг хөрөнгө юм" гэсэн тодорхойлолттой нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан бүх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд Төрийн өмчийн

бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу бүртгэх талаар аудитын зөвлөмж өгөх.

### 2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 23,580.0 мянган төгрөгийн хөрөнгө тодорхой тушаал шийдвэргүй Эрүүл мэндийн яаманд ашиглагдаж, биетээр оршин байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт, ТӨБЗГ-ын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, даснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчиж, аудитын "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарагдах үндсэн хөрөнгийг бүртгэж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

### 2.9.4 Зардлын талаар

Зардлын дансны бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:


Бараа материалын дансаар дамжуулалгүй 13,146.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2015 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг тус тус зөрчиж, "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулах.

Зардлыг зориулалт бусаар эдийн засгийн ангилал зөрчин 3,854.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2015 оны 55 дугаар тушаал хавсралт, 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн төслийг бодитойгоор зөв төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулах, мөн алдааг давтахгүй ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

Тайлант онд гадаад сургалт томилолтын зардлын төсвийг валютгаар олгохдоо Арилжааны банкны ханшаар тооцож олгосон, дотоод томилолтыг олгохдоо Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчин илүү олгосон байна. Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар баталсан "Зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай", мөн оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" гэсэн тушаалуудтай нийцэхгүй байгаа нь аудитын "Хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2011 оны 132, 188 дугаар тушаалуудыг мөрдөж ажиллах, алдааг давтан гаргахгүй байх талаар аудитын зөвлөмж өгөх.

## **2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

## **2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу магадлан итгэмжлэлийн үйлчилгээний орлогыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛИЙН НЭГТГЭЛ**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 91,196.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 25,361,5 мянган төгрөгийн алдааг залруулж, 65,8351 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

## **2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**


Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Материаллаг байдлыг төлөвлөлтийн үед 2017 оны батлагдсан төсвийн орлогын 2.0 хувиар буюу 81,911.1 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үед 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,360,814.2 мянган төгрөгийн 2 хувь 87,216.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

## **2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



### 3.1 Авлагын талаар

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага тайлант хугацаанд тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын үйлчилгээний орлого 6,517.8 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэсэн заалт, аудитын "Хэмжилт" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.


#### ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу авлага дансанд бүртгэж залруулах.

#### Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

#### Төсвийн захирагчийн хариу



**3.2 БАРАА МАТЕРИАЛЫН ТАЛААР****Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Бараа материалын бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Шатахуун зарцуулалтыг тулгаж шалгахад 12,636.6 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг хянаж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, аудитын "Толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тооллогоор 1385 ширхэг буюу 5,696.9 мянган төгрөгийн мэргэжлийн гэрчилгээнүүд дутагдав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тооллогоор үндсэн хөрөнгийн шинж чанартай 38 ширхэг 25,764.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд ангилал буруу бүртгэсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, даснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "... энэ журмын 4.2-т заасны дагуу зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан ... хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж бүртгэнэ" гэсэн заалт, ЭМЯ-ны 2015 оны НБББББ-ийн 4.4.4-т "Үндсэн хөрөнгө гэдэг нь ... тухайн байгууллагын эзэмшилд байгаа нэг жилээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдах, анхны өртгөө элэгдлийн байдлаар зардалд аажмаар шингээж байдаг хөрөнгө юм" гэсэн тодорхойлолттой нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу авлага дансанд бүртгэж залруулах.

Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан бүх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу бүртгэх талаар аудитын зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

### 3.3 Үндсэн хөрөнгийн талаар

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 23,580.0 мянган төгрөгийн хөрөнгө тодорхой тушаал шийдвэргүй Эрүүл мэндийн яаманд ашиглагдаж биетээр оршин байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт, ТӨБЗГ-ын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, даснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчиж, аудитын "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.


#### ҮАГ-ын зөвлөмж

Иймд өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарагдах үндсэн хөрөнгийг бүртгэж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

#### Эрсдэлүүд

Үндсэн хөрөнгө шамшигдах,



**3.4 Зардлын талаар****Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

Зардлын дансны бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн 3,854.0 мянган төгрөгийг бүртгэсэн нь Сангийн сайдын 2015 оны 55 дугаар тушаал хавсралт, 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг зөрчсөн байна.

Бараа материалын дансаар дамжуулалгүй 13,146.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2015 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг тус тус зөрчиж, "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант онд гадаадад нарийн мэргэжил дээшлүүлэх сургалтын томилолтын төсвийг Арилжааны банкны ханшаар тооцож олгодог, дотоод томилолтуудын байрны зардлыг 35.0 мянган төгрөгөөр тус тус тооцсон байна. Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар баталсан "Зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай", мөн оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" гэсэн тушаалуудтай нийцэхгүй байгаа нь аудитын "Хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Эрсдэлүүд**

Үргүй зардал гаргах, санхүүгийн сахилга бат алдагдах,

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийг бодитойгоор зөв төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулах, мөн алдааг давтахгүй ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2- д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулах.

Сангийн сайдын 2011 оны 132, 188 дугаар тушаалуудыг мөрдөж ажиллах, алдааг давтан гаргахгүй байх талаар аудитын зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



#### 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

##### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт                                                     | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                        | <b>137,730,155.60</b>   | <b>153,571,580.63</b>   |
| <b>АВЛАГА</b>                                                         | <b>6,056,237.40</b>     | <b>23,740,942.31</b>    |
| Бусад авлага                                                          | 6,056,237.40            | 23,740,942.31           |
| Байгууллагаас авах авлага                                             | 6,056,237.40            | 23,740,942.31           |
| <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                                                 | <b>131,673,918.20</b>   | <b>129,830,637.72</b>   |
| <b>Түүхий эд материал</b>                                             | <b>27,755,022.00</b>    | <b>27,653,922.00</b>    |
| Тусгай зориулалттай материал                                          | 8,345,050.00            | 8,243,950.00            |
| Эм боох материал                                                      | 19,409,972.00           | 19,409,972.00           |
| Бэлэн бүтээгдэхүүн                                                    | 85,520,272.00           | 84,625,887.00           |
| <b>Хангамжийн материал</b>                                            | <b>18,398,624.20</b>    | <b>17,550,828.72</b>    |
| Бичиг хэргийн материал                                                | 2,859,537.60            | 6,951,324.00            |
| Аж ахуйн материал                                                     | 0.00                    | 129,530.00              |
| Сэлбэг хэрэгсэл                                                       | 1,290,211.88            | 645,000.00              |
| Түлш шатах туслах материал                                            | 11,560,600.00           | 7,924,000.00            |
| Барилгын засварын материал                                            | 2,688,274.72            | 1,900,974.72            |
| <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>1,944,426,308.85</b> | <b>1,670,129,980.10</b> |
| <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                                                 | <b>1,944,426,308.85</b> | <b>1,670,129,980.10</b> |
| <b>Биет хөрөнгө</b>                                                   | <b>1,890,042,899.46</b> | <b>1,596,293,979.15</b> |
| Барилга байгууламж                                                    | 3,594,996,551.00        | 3,599,564,415.00        |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (2,425,098,965.08)      | (2,502,217,418.32)      |
| Авто-тээврийн хэрэгсэл                                                | 160,265,094.33          | 111,793,120.00          |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (119,732,185.79)        | (79,833,120.08)         |
| Машин тоног төхөөрөмж                                                 | 1,285,771,643.49        | 1,231,768,484.89        |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (709,860,675.33)        | (855,317,195.25)        |
| Тавилга, эд хогшил                                                    | 263,385,359.00          | 259,233,938.00          |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (167,359,811.45)        | (175,631,734.34)        |
| Бусад үндсэн хөрөнгө                                                  | 3,712,000.00            | 3,712,000.00            |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (804,266.71)            | (1,546,666.75)          |
| Номын фонд                                                            | 4,768,156.00            | 4,768,156.00            |
| <b>Биет бус хөрөнгө</b>                                               | <b>54,383,409.39</b>    | <b>73,836,000.95</b>    |
| Програм хангамж                                                       | 59,177,093.55           | 86,677,093.55           |
| Хуримтлагдсан элэгдэл                                                 | (37,089,184.16)         | (45,136,592.60)         |
| Бусад биет бус хөрөнгө                                                | 32,295,500.00           | 32,295,500.00           |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>2,082,156,464.45</b> | <b>1,823,701,560.73</b> |
| <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>2,082,156,464.45</b> | <b>1,823,701,560.73</b> |
| <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>2,082,156,464.45</b> | <b>1,823,701,560.73</b> |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,390,485,153.08        | 2,390,485,153.08        |
| Өмч: - төрийн                                                         | (886,474,054.63)        | (886,474,054.63)        |
